



Я.БАТГЭРЭЛ
Налайх дүүрэг дэх
шийдвэр
гүйцэтгэлийн
хэсгийн дарга,
докторант, хошууч

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРЛИЙГ БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРӨЛТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Монгол Улсын хувьд газар зүй геополитекийн хувь мөнхийн хөрш болсон ОХУ, БНХАУ-ын улс төр, нийгэм эдийн засгийн байдал, соёл уламжлал, зан заншил, хууль тогтоомж зэргийг зайлшгүй судлах шаардлагатай билээ. Монгол улсын Эрүүгийн хуулийн ялын төрлийг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн ялын төрөлтэй дараах эх сурвалжийн хүрээнд харьцуулсан судаллаа.

Монгол улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Улсын их хурлаас Эрүүгийн хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр шинэчлэн баталж, мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

БНХАУ-ын эрүүгийн хуулийг БНХАУ-ын 8-р хуралдааны тус улсын Ардын төлөөлөгчдийн их хурлын 5-р хураладаанаас 1997 оны 3 дугаар сарын 14-ний өдөр засвар

оруулж тогтоожээ.¹ Уг хуулийг 1997 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

Монгол улсын болон БНХАУ-ын Эрүүгийн хуульд заасан ялын төрлүүдийг харьцуулалтын аргаар ялын төрлийг зэрэгцүүлэн жишиж тодорхойлох замаар харьцуулан авч үзлээ.

Харьцуулсан эрүүгийн эрх зүйн шижлэх ухааны дээрх аргыг хууль зүйн шинжлэх ухааны доктор Д.Баярсайхан өөрийн бүтээлдээ “Дэлхийн улс орнуудын эрүүгийн хууль тогтоомж, тэдгээр актуудыг бүхэлд нь буюу институт бүлэг, хэсгээр нь нормативийн аргаар харьцуулах, улмаар гэмт хэрэг, ялын талаар эрх зүйн хэм хэмжээний хэлбэр, бүтэц, агуулага тогтолцоог зэрэгцүүлэн жишиж тодорхойлох зэргээр институцын түвшинд харьцуулж авч үзэх нь арга зүйн хувь чухал нөлөө үзүүлнэ.”² “ гэж тодорхойлсон байдаг.

Монгол улсын Эрүүгийн хуулийн есдүгээр бүлэгт эрүүгийн хариуцлагын зорилго, төрлийг тодорхойлж, ялын төрлүүдийг тодорхойлж, ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр ангилжээ.

¹ Г.Батзориг, Э.Зуунасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль орчуулга УБ хот. 2006 он.

² Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ хот. 2012 он. 22 дахь тал

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн гуравдугаар бүлэгт эрүүгийн шийтгэлийн төрлийг тодорхойлж гол эрүү ба нэмэлт эрүү гэж хуваасан байна.

Монгол улсын эрүүгийн хуульд үндсэн ял 5, нэмэгдэл ял 1, үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэлэх ял 1 байхаар хуульчилсан.

Харин БНХАУ-ын эрүүгийн хуульд гол эрүүгийн төрөл /үндсэн ял/ 5, нэмэлт эрүүгийн төрөл /нэмэгдэл ял/ 3 байхаар хуульчисан бөгөөд нэмэлт эрүүгийн төрлийг

дангаар нь тохируулан хэрэглэж болохоор хуульчилжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
Есдүгээр бүлэг Эрүүгийн хариуцлагын зорилго, төрөл	Гуравдугаар бүлэг Эрүү шийтгэл Нэгдүгээр хэсэг Эрүүгийн шийтгэлийн төрөл
46 дугаар зүйл. Ялын төрөл 46.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан ял оногдуулна:	32-р зүйл. Эрүүгийн шийтгэлийг гол эрүү ба нэмэлт эрүү гэж хуваана
46.1.1. торгох; 46.1.2. тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; 46.1.3. эд хөрөнгө хураах; 46.1.4. албадан ажил хийлгэх; 46.1.5. баривчлах; 46.1.6. хорих; 46.1.7. цаазаар авах.	33-р зүйл. Гол эрүүгийн төрөл зүйл нь доорхи мэт байна. (Нэг) Захиран хамаарах; (Хоёр) Хорьж хөдөлмөрлүүлэх; (Гурав) Хугацаатай хорих; (Дөрөв) Хугацаагүй хорих; (Тав) Алахаар шийтгэх;
46.2. Торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартай, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартай, эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ.	34-р зүйл. Нэмэлт эрүүгийн төрөл зүйл нь доорх мэт байна. (Нэг) Зоосоор ялгах; (Хоёр) Улс төрийн эрхийг хасах; (Гурав) Эд хөрөнгийг хурааж авах; Нэмэлт эрүүг дангаар нь тохируулан хэрэглэж ч болно.

ТОРГОХ ЯЛ

Монгол улсын хувьд үндсэн ял бөгөөд эрүүгийн хуулинд торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоож торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болхоор хуульчилсан.

БНХАУ-ын хувьд нэмэлт ялд тооцдог. Эрүүгийн хуульд

торгуулийн хэмжээг хэд байхыг томьёолоогүй байна. Харин хориглогдошгүй гай гамшиг учирвал, нөхцөл байдлыг тодруулж торгуулийн хэмжээг багасгах эсвэл бүрэн хэтрүүлж болохоор хуульчилсан нь дэвшилттэй зүйл байна гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
47 дугаар зүйл. Торгох 47.1. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ. 47.2. Торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтооно. 47.3. Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно. 47.4. Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ялыг торгох ялаар солихыг хориглоно.	Зургаадугаар хэсэг Зоосоор яллах 52-р зүйл. Зоосоор яллахаар шийтгэхдээ хийсэн ялынх нь үйл байдлыг үзэж яллах зоосны тоог тогтоох ёстой. 53-р зүйл. Ялласан зоосыг шүүн таслалт тогтоосон хугацааны дотор нэг удаад буюу хугацаа хувааж тушаана. Хугацаа дүүргэлт тушаахгүй байвал албадан тушаалгана. Ялласан зоосыг бүгдийг тушааж дийлэхгүй байвал Ардын шүүх хороо гүйцэтгэгч хүнд гүйцэтгэж болох эд хөрөнгийг нь олж мэдмэгц цаг тухайд нь нэхэмжилж тушаалгах ёстой. Хориглогдошгүй гай гамшиг тушаахад үнэхээр учиртай болон байвал байдлыг нь үзэж багасгах буюу хэтрүүлж болно.

ЭРХ ХАСАХ ЯЛ

Монгол улсын хувьд эрхэлж буй тодорхой албан тушаал, явуулж буй үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох буюу үйл ажиллагаа явуулахгүй байхаар, үндсэн болон нэмэгдэл ялын

чанартай хэрэглэхээр, ялын хугацаа болон ялыг хэрхэн тоолох зэргийг нарийвчлан зохицуулсан байхад БНХАУ-д нэмэгдэл ялын чанартай хэрэглэж Улс төрийн эрхийг нь хасаж шийтгэдэг байна.

Улс төрийн эрхэд сонгох сонгогдох эрх, үг хэлэх, хэвлэн

нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн нэгдэх, жагсаал цуглаан явуулах, Төрийн байгууллагад албан тушаал хаших, Улсын өмчлөлийн компанид аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын байгууллагад удирдах албан тушаал хаших зэргийг хамааруулдаг байна.

Монгол улсад эрх хасах ялыг албан тушаалтан болон тодорхой эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй этгээдэд оногдуулдаг бол БНХАУ-д улсын болон хувийн хэвшлийн удирдах ажилтан болон жирийн иргэнд ч оногдуулж болох байдлаар зохицуулжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
48 дугаар зүйл. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах 48.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ. 48.2. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь үндсэн ялыг эдэлж дууссан үеэс эхлэн тоолох ба хорих ялыг тэнссэн бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно. 48.3. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг торгох, албадан ажил хийлгэх ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно.	Долдугаар хэсэг Улс төрийн эрхийг нь хасах 54-р зүйл. Улс төрийн эрхийг нь хасах гэж доорхи эрхүүдийг хасах болно. 1, Сонгох эрх ба сонгогдох эрх; 2, Үг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөт эрх; 3, Төрийн байгууллагад тушаал үүрэх эрх; 4, Улсын өмчлөлийн компанид аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын бүлгийг жолоодох тушаал үүрэглэх эрх; 55-р зүйл. Улс төрийн эрхийг нь хасах хугацааг нь тус хуулийн 57-р зүйлд тогтоосныг гаргавал нэг жилээс дээш, таван жилээс доош байлгана. Захиран хамаарахаар шийтгээд улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэсэн байвал улс төрийн эрхийг хасах хугацаагаар захиран хамаарахын хугацаатай адил байлгах зэргээр гүйцэтгэнэ. 56-р зүйл. Улсын амар төвшинд хор хөнөөл учруулсан ялт этгээдэд улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэх ёстой. Зориуд хүн алсан, хүчиндсэн, гал тавьсан, хор хаясан, тонон дээрэмдсэн зэрэг нийгмийн эмх дэглэмийг хүнд ноцтой эвдсэн ялт этгээдийн улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэж болно. Улс төрийн эрхийг нь хасахаар дангаар тохируулан хэрэглэвэл хуулийн хуваарь дүрмийн тогтоолыг үндэслэнэ. 57-р зүйл. Алах эрүү ба хугацаагүй хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн улс төрийн эрхийг нь нэг насаар нь хасах ёстой. Алах эрүүг нь алгуурлан гүйцэтгэх эрхийг нь хугацаатай хорих болгон хөнгөрүүлэх үед улс төрийн эрхийг нь хасах нэмэлт эрүүг нь гурван жилээс дээш арван жилээс доош

	болгож бууруулах ёстой. 58-р зүйл. Улс төрийн эрхийг нь хасах нэмэлт эрүүгийн хугацааг хорих эрүү, хориж хөдөлмөрлүүлэх эрүү дуудсан өдөр буюу тэнсэн сулласан өдрөөс эхлэн бодно. Улс төрийн эрхийг хасах эрүү нь гол эрүүгийн гүйцэтгэлийн хугацаанд хүчинтэй. Улс төрийн эрх нь хасагдсан ялт этгээд гүйцэтгэлийн хугацаанд хууль цааз, засаг захиргааны хууль тогтоол болон төрийн албаны хорооны дотоодыг хамгаалах салаа мөчрийн хамаа бүхий хянан хамааралтын тухай тогтоолыг журамлан сахиж хяналтыг дагах ёстой. Тус хуулийн 54-р зүйлд тогтоосон эрхүүдийг хэрэглэж болохгүй.
--	---

ЭД ХӨРӨНГӨ ХУРААХ

Эд хөрөнгө хураах ялын зохицуулалтын хувьд төсөөтэй зүйл нэлээдгүй байна. Тухайлбал нэмэгдэл ялын чанартай хэрэглэдэг, гэмт этгээдийн хувьд ноогдох /хувийн өмчлөлийн/ хөрөнгийг бүгдийг буюу нэг хэсгийг /шүүхийн тогтоолд заасан эд хөрөнгийг/ хураан авахаар хуульчилсан боловч

БНХАУ-ын хувьд эд хөрөнгө хураан авахаас өмнө гэмт этгээдийн бусдад төлөх төлбөрийг /шүүхээр баталгаажсан/ төлбөр авагчийн хүсэлтээр барагдуулахаар хуульчилсан нь гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдлыг дээрдүүлж хохирол барагдуулахад нэлээд ахиц гаргасан зохицуулалт болжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
49 дүгээр зүйл. Эд хөрөнгө хураах 49.1. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ. 49.2. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана. 49.3. Шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.	Наймдугаар хэсэг Эд хөрөнгийг нь хураан авах 59-р зүйл. Эд хөрөнгийг нь хураан авах ялт этгээдийн хувийн өмчлөлийн нэг хэсэг буюу бүгдийг нь хурааж авах явдал болно. Эд хөрөнгийг нь бүгдийг нь хурааж авахдаа ялт этгээдийн хувь хүн хийгээд түүний асран тэжээж байгаа гэр бүлийнхэнд чухал бүхий амьдралын зардал үлдэх ёстой. Эд хөрөнгийг нь хураан авхаар шийтгэхдээ ялт этгээдийн бүлийнхний өмчлөл болох буюу эдлэх эрхтэй эд хөрөнгийг нь хурааж болохгүй. 60-р зүйл. Эд хөрөнгийг хураан авахаас өмнө ялт этгээдийн зүй ёсны өрийг хураан авсан эд хөрөнгөөр төлөх чухалтай байвал авцаатны хүсэлтээр төлөх ёстой.

АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ

Дээрх ял шийтгэл БНХАУ-ын эрүүгийн хуулийн ял шийтгэлийн төрөлд байдаггүй бөгөөд Монгол улсын ялын төрөлд дараах байдлаар тодорхойлжээ. Уг ялыг үндсэн ялын чанартай хэрэглэх бөгөөд нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ. Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хоног

баривчлах ялаар тооцож сольж болохоор зохицуулсан бөгөөд хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулахгүй байхаар хуульчилжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
50 дугаар зүйл. Албадан ажил хийлгэх 50.1.Энэ хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ. 50.2.Албадан ажил хийлгэх ял нь нэг зуугаас таван зуун цагийн хугацаатай байна. Албадан ажил нь нэг өдөрт гурван цагаас доошгүй хугацаагаар үргэлжилнэ. 50.3.Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож солино. 50.4.Хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулахгүй.	

БАРИВЧЛАХ ЯЛ

Монгол улсын эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд заасан баривчлах ялын төрлийг БНХАУ-ын эрүүгийн хуулийн гуравдугаар бүлэгт заасан хорьж хөдөлмөрлүүлэх ялын төрөлтэй харьцуулан үзлээ. Дээрх ялын төрлүүд нь адилхан нэг сараас зургаан сар хүртэл

хугацаагаар хорих бөгөөд БНХАУ-д ял шийтгэгдсэн этгээдийг хорьж хөдөлмөрлүүлж, мөн ажлын хөлсийг тооцож олгодог байхаар зохицуулжээ. 2 улсын хувьд дээх ялыг үндсэн ялын чанартайгаар хэрэглэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
51 дүгээр зүйл. Баривчлах 51.1. Энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгахыг баривчлах ял гэнэ. 51.2. Баривчлах ялыг нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар оногдуулна. 51.3. Баривчлах ялыг шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван зургаан насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, бага насны хүүхэдтэй ганц бие эх, эцэгт оногдуулахгүй. 51.4. Цэргийн жинхэнэ хугацаат албан хаагчид оногдуулсан баривчлах ялыг сахилгын байранд ганцаарчлан эдлүүлнэ.	Гуравдугаар хэсэг Хорьж хөдөлмөрлүүлэх 42-р зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэх хугацааг нэг сараас дээш зургаан сараас доош байлгана. 43-р зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэх шийтгэгдсэн ялт этгээдийг дотоодын хамгаалах байгуулагад ойрхон газарт нь гүйцэтгэнэ. Гүйцэтгэлийн хугацаанд хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэгдсэн ялт этгээд сард нэгээс хоёр өдрийн чөлөөгөөр гэртээ харьж болно. Хөдөлмөрт оролцвол зохих хэмжээний хөлс хүч олгож болно. 44-р зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэхийн эрүүгийн хугацааг нь шүүх таслалтыг эрхлэн гүйцэтгэх өдрөөс бодно. Шүүн таслалтыг гүйцэтгэхээр өмнө урьдаар хорьсон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацаанд нэг өдрөөр тооцно.

ХОРИХ ЯЛ

Хорих ялын үндсэн хугацаа адил 15 жил хүртэл байх бөгөөд Монгол улсад хуулийн тусгай ангид заасан тохиолдолд 25 жил хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан бол БНХАУ-д зарим гэмт хэрэгт оногдуулах ялыг хугацаагүй хорихоор шийтгэдэг байна.

Хуульд хорих дэглэмийг зааж өгсөн нь 2 улсын эрүүгийн хуульд адил мэт боловч Монгол улсын

хувьд үйлдсэн хэргийн хувьд хүнд, хөнгөн, гэмт этгээдийн нас, хүйс, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос ял эдлэх дэглэмийг хуульчилж өгсөнөөрөө онцлог байна.

БНХАУ-ын хувьд хорих ял шийтгүүлсэн этгээд хөдөлмөрлөх чадалтай бол заавал хөдөлмөрт оролцож хүмүүжигдэн өөрчлөгдөх талаар хуульчилжээ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
52 дугаар зүйл. Хорих 52.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгахыг хорих ял гэнэ. 52.2. Хорих ялын үндсэн хугацаа нэгээс арван таван жил хүртэл байна. Хорих ялыг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар оногдуулж болно. 52.3. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд	Хугацаатай хорих, хугацаагүй хорих 45-р зүйл. Хугацаатай хорих хугацааг тус хуулийн 50-р зүйл, 69-р зүйлд тогтоосныг гаргавал 6 сараас дээш арван таван жилээс доош байлгана. 46-р зүйл. Хугацаатай хорих, хугацаагүй хорихоор шийтгэгдсэн ялт этгээдийг гянданд буюу бусад гүйцэтгэх талбарт гүйцэтгэнэ. Хөдөлмөрөх чадалтай нь цөм хөдөлмөрт оролцож, хүмүүжигдэн өөрчлөгдөх ёстой. 47-р зүйл. Хугацаатай хорих эрүүгийн хугацааг шүүн таслалтыг эрхлэн гүйцэтгэх өдрөөс тооцно. Шүүн таслалтыг гүйцэтгэхээс өмнө урьдаар хорьсон байвал хоригдсон нэг

арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй. 52.4. Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлнэ. 52.5. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.6. Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан, анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.7. Хоёр ба түүнээс дээш удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.8. Хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтан, хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.9. Урьд нь хорих ял эдэлж байсан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.10. Шүүх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, ялтны хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хорих ял эдлүүлэх дэглэмийг хөнгөрүүлж буюу чангаруулан өөрчилж болно. Ийнхүү шийдвэрлэсэн шалтгааныг шийтгэх тогтоолд заана. 52.11. Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон болон арван найман насанд хүрсний дараа онц хүнд гэмт хэрэгт арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эрэгтэй ялтны хорих ялын заримыг гянданд эдлүүлэхээр шүүх тогтоож болно.	өдрийг нь эрүүгийн хугацааны нэг өдрөөр тооцно.
--	--

ЦААЗААР АВАХ ЯЛ

Цаазаар авах ял 2 оногдуулж болохгүй нөхцөлийг Монгол улсад 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд, БНХАУ-д 18 насанд үл хүрсэн ба шүүн таслах үед жирэмсэн байх эмэгтэйд хэрэглэхгүй байхаар зохицуулжээ. Дэлхий нийтээр цаазаар авах ялаас татгалзаж байгаа өнөө үед Монгол улсын ерөнхийлөгч Монгол улсыг цаазын ялгүй орон хэмээн зарлаж, цаазаар авах ялыг гүйцэтгэхийг түдгэлзүүлээд байгаа билээ. Харин БНХАУ-д ял үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй болон шүүн таслах үед жирэмсэн байгаа эмэгтэйд алах ялыг хэрэглэхгүй бөгөөд бусад этгээдэд хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн бол алах ялыг хэрэглэхээр зохицуулжээ. Монгол улсын эрүүгийн хуульд ялыг буудаж гүйцэтгэхээр заасан бөгөөд дээрх ялаар шийтгүүлсэн этгээд өөрөө хүсвэл Монгол улсын ерөнхийлөгчөөс уучлал хүсэхээр, Монгол улсын ерөнхийлөгч амийг уучилсан тохиолдолд 30 жилийн хугацаагаар хорихл ялаар солихоор хуульчилсан. Харин БНХАУ-ын хувьд Ардын шүүх хорооны шүүн таслахаас бусад алах эрүүг бүгдийг нь Ардын дээд шүүх хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх ёстой бөгөөд алах эрүүг алгуурлан гүйцэтгэхийг ардын өндөр зэргийн шүүх хороо шүүн таслах буюу хянан

зөвшөөрч болно. Алгуурлан гүйцэтгэх хугацаа хугац 2 жил байхаар зохицуулсан бөгөөд энэ хугацаанд зориуд ял хийгээгүй байвал хоёр жилийн хугацаа нь дууссаны дараа хугацаагүй хорих болгож хөнгөрүүлнэ. Үнэнхүү чухал их гавъяа байгуулсан нь илрэлтэй байвал хоёр жилийн хугацаа дууссаны дараа арван таван жилээс дээш, хорин жилээс доош хугацаатай хорих болгон хөнгөрүүлдэг байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
53 дугаар зүйл. Цаазаар авах 53.1. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болно. 53.2. Цаазаар авах ялыг буудаж гүйцэтгэнэ. 53.3. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино. 53.4. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй.	Тавдугаар хэсэг Алахаар шийтгэх 48-р зүйл. Эрүүг гагцхүү туйлын хүнд ял хийсэн ялт этгээдэд л тохируулан хэрэглэнэ. Алахаар шийтгэх ёстой ялт этгээдийг заавал доор нь гүйцэтгэх хэрэгтэй биш байвал алахаар шийтгэхийг хоёр жил алгуурлан гүйцэтгэж болно. Хууль ёсоор Ардын шүүх хорооны шүүн таслахаас бусад алах эрүүг бүгдийг нь Ардын дээд шүүх хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх ёстой. Алах эрүүг алгуурлан гүйцэтгэхийг ардын өндөр зэргийн шүүх хороо шүүн таслах буюу хянан зөвшөөрч болно. 49-р зүйл. Ял хийх үедээ бүх л арван найман насанд үл хүрсэн ба шүүх таслах үед жирэмсэн байх эмэгтэйд алах ялыг тохируулан хэрэглэхгүй. 50-р зүйл. Алахаар шийтгэхээр алгуурлан гүйцэтгэгсэд алахыг алгуурлан гүйцэтгэх хугацаа нь хэрвээ зориуд ял хийсэнгүй байвал хоёр жилийн хугацаа нь дууссаны дараа хугацаагүй хорих болгож хөнгөрүүлнэ. Үнэнхүү чухал их гавъяа байгуулсан нь илрэлтэй байвал хоёр жилийн хугацаа дууссаны дараа арван таван жилээс дээш, хорин жилээс доош хугацаатай хорих болгон хөнгөрүүлнэ. Хэрвээ зориуд ял хийсэн бөгөөд байцаан тодлоод үнэн магад байвал. Ардын дээд шүүх хороогоор хянан зөвшөөрүүлээд алах эрүүг гүйцэтгэнэ. 51-р зүйл. Алахаар шийтгээд алгуурлан гүйцэтгэх хугацааг нь шүүх таслалтыг нь тогтоосон өдрөөс эхлэн бодно. Алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэхийг хугацаатай хорих болгон хөнгөрүүлсэн байвал түүний эрүүгийн хугацаатай хорих болгон хөнгөрүүлсэн байвал түүний эрүүгийн хугацааг түүний алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэх хугацаа дууссан өдрөөс эхэлж болно.

ЗАХИРАН ХАМААРАХ ЯЛ

БНХАУ-н эрүүгийн хуулийн
38-р зүйлд Захиран хамаарах

эдийн засгийн байдал, соёл, өв
уламжлал, ёс заншил, төрийн
тогтолцоо, эрх зүйн бүлээсээ хамаарч

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
	Захиран хамаарах 38-р зүйл. Захиран хамаарах хугацааг гурван сараас дээш, хоёр жилээс доош байлгана. Захиран хамаарагдахаар ял этгээдийг Дотоод хамгаалах байгууллагаас гүйцэтгэнэ. 39-р зүйл. Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээд гүйцэтгэлийн хугацаандаа доорхи тогтоолуудыг журамлан сахих ёстой. (Нэг) Хууль цааз, засаг захиргааны хууль, тогтоолыг журамлан сахих, (Хоёр) Гүйцэтгэх байгууллагын зөвшөөрөлгүйгээр уг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэрэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөт эхийг хэрэглэх болохгүй (Гурав) Гүйцэтгэх байгууллагын тогтоолоор еерийн ажиллагааны байдлаа мэдүүлэх үүрэгтэй (Дөрөв) Зочинтой уулзах тухай Гүйцэтгэх байгууллагын тухай журмыг журамлан сахих хэрэгтэй. (Тав) Сууж байгаа хот, саянаас салах буюу нүүж явбал гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж зөвшөөрүүлэх ёстой. Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээдэд хөдөлмөрийн дунд адил хөдөлмөрт адил хөлс авах ёстой. 40-р зүйл. Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээдийн захиралтын хугацааг нь дүүрвэл гүйцэтгэх байгууллага нь тус хүн ба түүний байгаа нэгжид нь буюу сууж байгаа газрынх нь олон түмэнд захирагдлаас чөлөөлсөнийг нь захирвал зохино. 41-р зүйл. Захиран хамаарах эрүүгийн хугацааг нь шүүн таслалтыг гүйцэтгэсэн өдрөөс эхэлж бодно. Шүүн таслалтыг нь гүйцэтгэхээс өмнө урдаар хорисон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацааны хоёр өдрөөр нугалан бодно.

хугацааг гурван сараас дээш, хоёр
жилээс доош байлгана. Захиран
хамаарагдахаар ял этгээдийг Дотоод
хамгаалах байгууллагаас гүйцэтгэнэ.

Доктор Д.Баярсайхан дээрх
ялыг Хяналт тогтоох ял¹ гэж
тодорхойлоод 2 сараас 3 жил хүртэл
хугацаатай байх бөгөөд дотоодыг
хамгаалах байгууллагын шууд
хяналтанд ялыг хэрэгжүүлдэг байна.
Монгол улсын хувьд дээрх ялын
төрөл хуульчлагдаагүй байна.

Монгол улсын Эрүүгийн
хуулийн ялын төрлийг БНХАУ-ын
Эрүүгийн хуулийн ялын төрөлтэй
харьцуулан судалхад 2 улсын ял
шийтгэлийн төрөл ерөнхийдөө адил
төстнй бөгөөд тухайн орны нийгэм

тус тусын онцлогтой байна.

Судалгааны явцад БНХАУ-ын
хорих ялын бодлого нь хорих ялаар
шийтгэгдсэн этгээдийг заавал ажил
хөдөлмөр эрхлүүлэхэд оршдог
бөгөөд энэ нь уг хуулийн
хөдөлмөрлөх чадалтай л бол заавал
хөдөлмөр эрхлүүлнэ гэж
томьёолсоноос тодхон харагдана.

Мөн торгох ялыг хэмжээг
хуульд тодорхой зааж өгөөгүй байгаа
нь тухайн гэмт этгээдийн хөрөнгө
чинээ, орлого зэргийг харгалзан
шүүхээс тогтоож болохоор нээлттэй
байгааг Монгол улсад тусган авч
хэрэгжүүлэх зүйтэй байна. Хуулийн
дээрх заалт өдгөө манай улсад
шүдний өвчин мэт асуудал үүсгэж
байгаа торгуулийн ялын биелэлтэнд
чухал ахиц гаргана гэж судлаачийн
хувьд үзэж байна.

¹ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх
зүй. УБ хот, 2006 он. 259 дэх тал

Гэмт этгээдийн эд хөрөнгийг
хураахаас өмнө төлбөр авагч,
хохилогчийн хохирол төлбөрийг
эхлэн барагдуулж байгаа нь
сайшаалтай байна.